



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

**ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН
ДҮРЭМ, БҮТЦИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар байгуулах тухай" Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 474 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын" гэснийг "Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын" гэж өөрчилсүгэй.
- 2."Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм"-ийг 1 дүгээр хавсралт, "Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтэц"-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.
- 3.Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж, мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаярт даалгасугай.
- 4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар байгуулах тухай" Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 474 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА Э.ОДБАЯР